# Дорноговь Цусны салбар төвийн 2019 оны үйл ажиллагаа

ЦСТөвийн эрхлэгч, эмч Ц.Тунгалаг

# 1. Цус сийвэн цуглуулалт

**2019 онд сууринггаар 289 нэгж цус сийвэн цуглуулах төлөвлөгөөтэй байсан бол 333 нэгж цус цуглуулан төлөвлөгөөний биелэлт 115 хувьтай, шинээр 63 донор элсүүлэхээс 47 донор элсүүлж биелэлт 75 хувьтай байна. Донорын үзлэг асуумжаар 19,6 хувь хасагдсан боловч өмнөх оныхоос 24,4 хувиар буурч, байнгын донорын эзлэх хувь 75,9 хувь байна.**






# Донорын сургалт сурталчилгаа

Сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор Аймгийн ИТХурал, Аймгийн ЗДТГазар, Сайншанд сумын ИТХурал, Сайншанд сумын ЗДТГазар, ЭМГазар, Нэгдсэн эмнэлэг, УЗХороо, Нийгмийн даатгалын хэлтэс, АШУҮИСургууль, Мишээлт мана-1, Мишээлт мана-2 өрхийн эмнэлэг, орон нутгийн DTY, DSB телевизтэй хамтран донорын сургалт сурталчилгааг сурталчилгааны самбар, гарын авлага зэргийг ашиглан нийт 3611 хүнд сургалт, сурталчилгаа хийсэн байна.










# Сар бүрийн 3-Цусаа бэлэглэх өдөр

Сар бүрийн 3-ны өдрийг нийт 8 удаа зохион байгуулснаар Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн хамт олон, АШУҮИСургуулийн “Чадварлаг эмгэг судлаач” клуб, “ 3D-25” клубын оюутанууд болон орон нутгийн ард иргэд донорын эгнээнд нэгдэж цусаа бэлэглэж, нийт 47 донор шинээр элсүүлсэн. Мөн 2019 онд цус цуглуулалттай холбоотой урвал, хүндрэл гараагүй байна.








# 2. Лабораторийн шинжилгээ

**Донороос цуглуулсан цусанд цус өгөхийн өмнө хийгдэх шинжилгээний жагсаалтын дагуу 100% шинжилгээнүүдийг давтан хийж баталгаажуулж ажилласан. Цус сэлбэлтээр дамжих В,С вирус, ДОХ, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээг ELISA-ийн аргаар 333 нэгж цусанд шинжилгээ хийлгэсэн. Графикаас харахад 2018 оныг 2019 онтой харьцуулахад шинжилгээний хасагдалт 64%-иар буурсан байна.**



- Цусны АВО болон резус бүлэг тодорхойлох шинжилгээг 2776 үйлчлүүлэгчид, цусны АВО, резус бүлэг тодорхойлсноос 0,1 хувь нь резус сөрөг байсан. 333 донорын Цусны АВО, резус, келл бүлгийг 100% тодорхойлж, Лабораторит хувийн тохироог 277 удаа тодорхойлсон.
- 2016 оны ЭМССайдын гаргасан 02 тоот тушаалын дагуу ийлдсийн сангийн бүртгэлийн журнал гарган ЦСТөв дээр бүртгэн хадгалж баримтжуулж байна.

ЭМССайдын 2016 оны 02 тоот тушаалын дагуу ийлдсийн санг бүртгэн баримжуулж байна.



Ийлдсийн санг хадгалж байгаа байдал





# 3. ЦЦБ-ний үйлдвэрлэл

**2019 онд 828 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байснаас 672 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.**



# ЦЦБ-ний тээвэрлэлт






# Эмнэлэгт олгосон ЦЦБүтээгдэхүүн /нэр төрөл, нэгжээр/

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 426 нэгж буюу 105387 мл цус, цусан бүтээгдэхүүнийг олгосон. Мөн 18 нэгж буюу 5847 мл УЭБ, 2 нэгж буюу 380 мл К.Сийвэн, 4 нэгж буюу 220 мл ХШСийвэн хугацаа дуусаны улмаас акталсан.






# Онцлох үйл ажиллагаа

Цусны донорын дэлхийн өдрийг “ Аюулгүй цус цусан бүтээгдэхүүн: Хэнд ч, Хаана ч” уриан дор тэмдэглэн аймгийн Соёмбо цогцолборын иргэний танхимд болж, нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ИТХурлын дарга С.Түмэнбаяр, Аймгийн НБХэлтсийн дарга Ч.Байгалтуяа, Сайншанд сумын Засаг дарга С.Одбаяр, аймгийн УЗХороон дарга Дэлгэрмаа, Нэгдсэн эмнэлгийн дарга Ц.Мөнхбаясгалан нар  хүрэлцэн ирж оролцсон.










**ЦДӨдрөөр нийт 32 доноруудыг алдаршуулж, 2 байгууллагыг Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч хамт олноор өргөмжилсөн байна.**











Хүмүүнлэгийн үйлсэд хамтран ажиллаж, халуун цусаа бэлэглэж байгаа донорууддаа урам хайрласан **“Сэтгэлийн илгээмж”** талархлын дэвтэр аялуулж хэвшсэн. Донорuудын эрүүл мэндэд хяналт тавьж, НЭ-т жилд 1 удаа очер дугааргүй, үнэ төлбөргүй үзүүлэх зорилгоор үнэмлэхжүүлсэн. Цусны донорын дэлхийн өдрийг тохиолдуулан Цусны салбар төв нь нийт донорууддаа гарын бэлэг гардуулж, олон нийтэд алдаршуулсан.
















# “Цусны 1000 донор”-ын Үндэсний чуулганд 20 донорыг оролцуулав.







**“Сар бүрийн 3”**-Цусаа бэлэглэх өдөрт зориулж анонс, донорын сургалт сурталчилгаанд брошурийн тавиур, 2 хөлтэй самбар, 5 нэр төрлийн 400 ширхэг гарын авлага хийж сургалт сурталчилгаандаа ашиглаж байна.












Цус сэлбэлт судлалын эрдэм шинжилгээний XV бага хуралд “Дорноговь ЦСТөвийн 2016-2018 оны үйл ажиллагаанд хийсэн судалгаа” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн.






Цус сэлбэлт судлалын эрдэм шинжилгээний XVI бага хурал

**Дорноговь Цусны салбар төвийн 2016-2018 оны үйл ажиллагаанд хийсэн судалгаа**

*Ц.Тунгалаг[1], Б.Бадамдулам[1]*
*[1]Дорноговь Цусны салбар төв*

**Үндэслэл.** Манай улсын хүн амын өвчлөл, нас баралтын үндсэн шалтгаанууд өөрчлөгдөж, хорт хавдар хоёрдугаар байрт орж хорт хавдрын илрэх хувь буурахгүй /75%/ байгаагаас томоохон мэс засал, химии, туяа эмчилгээний тоо нэмэгдсээр байна. Эхийн эндэгдлийн шууд шалтгааны нэгдүгээрт цус алдалт /24%/, цус алдаж хүндэрдэг дараах эмгэг байдлууд умайн урагдал /48%/, умайн гадуурх жирэмслэлт /16.7%/, нийтдээ 60 гаруй хувь нь зайлшгүй цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх эмчилгээг шаардаж байна. Мөн хүн амын дунд осол гэмтлийн тоо жилээс жилд өсч, өвчлөл нас баралтын үндсэн шалтгааны нэг болж байна. Цусны салбар төвийн донор зохион байгуулалт ба үйлдвэрлэл, хэрэглээг судалж үнэлэхэд судалгааны зорилго оршино.

**Арга, аргачлал.** Цусны салбар төвийн 2016-2018 оны цус цуглуулалт ба үйлдвэрлэлийн тайлан, статистикийн тоон мэдээг тооны аргаар боловсруулалт хийж, графикаар харууллаа.Анх удаа судлагдаж байгаа нь шинэлэг тал болно.

**Үр дүн.** Хүйсийн хувьд авч үзэхэд 52% нь эрэгтэй донорууд эзэлж байна. Нийт цусаа бэлэглэж байгаа доноруудын 33,3% нь 30-39 насны хүмүүс байна. Нийт доноруудын дунд шинэ донор 45,5%, байнгын донор 54,4%-ийг эзэлж байна. Иймд цаашид байнгын донорын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна. Цусны төв сүүлийн 3 жилийн хугацаанд 962 нэгж буюу 368000 мл цус цуглуулсан. 2016 онд 1623 мл буюу 7 нэгж, 2017 онд 605 мл буюу 3 нэгж, 2018 онд 856 мл буюу 4 нэгж цус цуглуулах үеийн хаягдал гарсан байна. Өвчлөлийн шалтгаанаар: B вирус - 15 , C вирус – 13, тэмбүү - 8 Сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 962 донорт ЦСДХИлрүүлэх шинжилгээг 100% хийсэн ба нийт хасагдалт 36 буюу 3,7%-ийг эзэлж байна.

2016 онд 117148 тл буюу 512 нэгж, 2017 онд 166147 тл буюу 696 нэгж, 2018 онд 182830 тл буюу 796 нэгж байжээ. Нөөцийн хэмжээ 2016 оныг 2018 онтой харьцуулахад 13,8% өссөн. Улаан эсийн бүтээгдэхүүний хаягдал нь 2016 онд 19 нэгж , 2017 онд 27 нэгж, 2018 онд 18 нэгж байсан бөгөөд 2017 болон 2018 оныг харьцуулж үзэхэд 66,6 хувиар буурсан байна. ЦЦБүтээгдэхүүний хэрэглээ 2016 онд 397нэгж, 2017 онд 503нэгж, 2018 онд 537нэгж бүтээгдэхүүн хэрэглэсэн болно. 2016 оныг 2018 онтой харьцуулахад цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ 26,1 хувиар өссөн харагдаж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд 1437 нэгж ЦЦБ хэрэглэсэн байна. Төрөх тасаг- 27%, Дотрын тасаг – 44%, Мэс засал-28%, Хүүхдийн тасаг -1,0%-ийг хэрэглэсэн байна. Мөн УЭБ сэлбэхийн өмнө хувийн тохироог 100% үздэг.

11






# Нэгтгэж савласан Криопреципитатыг шинээр хийж эмчилгээнд олгосон.








# Цус сэлбэлт хийсэн тасгуудын өвчний түүхэнд цус захиалга болон цус сэлбэлтийг хянах хяналтын хуудсыг боловсруулж ижил мэргэжилтний үзлэг хийж хэвшсэн.





Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үйл ажиллагааны хяналтын хуудас

Тасгийн нэр

| № | Зорилтот алхам | Ажиглалт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хянасан огноо | | | | | | | |
| 1 | Эмнэлэг, тасгийн нэр | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 2 | Өвчний түүхийн дугаар | 1822 | 1822 | 1991 | 2033 | 2114 | 2240 | |
| | Сэлбэсэн огноо | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Цус цусан бүтээгдэхүүн төрөл | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | ЦЦБ цуврал савлалтын дугаар | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Хуудийний код | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Цусны алба, ЭЗЦС нэгж/тасаг хүлээн авсан хугацаа | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Өвчтөн, асран хамгаалагчаас ЦЦБ сэлбэх зөвшөөрөл авсан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Эмч захиалгын хуудсыг баталгаажуулсан | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | ЦЦБ-ий төрлийг сонгосон эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Цусны АВО, резус бүлэг тодорхойлсон эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Өвчтөний нэр, цус захиалах маягтын нэртэй тохирч буй эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Цус захиалах хаягны мэдээлэл, сэлбэх ЦЦБ-ий хаягны мэдээлэл тохирч буй эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Өвчтөний мэдээлэл, ЦЦБ-ий захиалах хаягны мэдээлэл, хувийн тохирооны мэдээлэл тохирч байгаа эсэхийг дахин шалгасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Сэлбэх бүтээгдэхүүний цусны АВО, резус бүлэг | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Өвчтөний цус захиалах маягтны цусны АВО, Rh бүлэг | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Лабораторит баталгаажуулсан Цусны АВО Rh бүлэг | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | ЦЦБ-ий хүчинтэй хугацааг шалгасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Бүтээгдэхүүний хуудийний код, лабораторийн хувийн тохирооны шинжилгээний хариуны маягтны хуудийний кодтой тохирч байгаа эсэхийг шалгана | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Биологийн тохироо үзсэн эсэх | 0 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |



| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Биологийн тохироо тодорхойлсон дүн | 0 | 0 | 1 | 1 | 0 | 1 | |
| 22 | Сэлбэлтээс өмнө амин үзүүлэлтийг үзсэн эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 23 | Сэлбэлт эхэлсэн хугацааг тэмдэглэсэн эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 24 | Сэлбэлтийн эхний 15 минутанд амин үзүүлэлтийг үзсэн эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 25 | ЦЦБ сэлбэх хурдыг тодорхойлсон эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 26 | Сэлбэлтийн явцад 30 минут тутамд хянасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 27 | Сэлбэлтийн төгсгөлд хянасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 28 | Сэлбэлт дууссанаас хойш 3 цагт хянасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| 29 | Сэлбэлт дууссанаас хойш 24 цагт хянасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | |
| | Амин үзүүлэлтийг хянасан эсэх | 1 | 1 | 1 | 1 | | 1 | |
| | Өвчтөнөөс сорьц авсан талаар өвчний түүхэнд тэмдэглэсэн эсэх | 1 | 0 | 0 | 0 | 1 | 1 | |
| | Ажилбар гүйцэтгэсэн ажилтны нэр, албан тушаал | 93.5% | 93.5% | 96.7 | 96.7% | 93.5% | 100% | |
| | Хяналт хийсэн ажилтны нэр, албан тушаал | | | | | | | |

Тайлбар: Нийт 31 оноо авна. /Гүйцэд -1 оноо, дутуу-0 оноо/



# БНХАУ-ын Шанхайн сургалтаас Стандартад нийцсэн сийвэнг таних аргыг нэвтрүүлэв.











2019 оны 9-р сарын 21-22нд Дорноговь аймагт **“Говийн чоно-2019”** гамшгаас хамгаалах иж бүрэн үзүүлэх сургалтанд ЦСТөв нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Цус сэлбэх хөдөлгөөнт хэсгийн гэрийг тохижуулж ***“Онцсайн”*** үнэлгээтэй оролцсон.










“Сумын түвшинд цусны аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг хэвшүүлье” сэдэвт сургалтыг өрх, сумдын эмч нарт ЦССҮТөв, ЭМГазартай хамтран зохион байгуулсан.







Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч болон 14 сумдын эмч нарт “Донор сонголт ба цус сэлбэлт”, “ЦЦБ зохистой хэрэглээ” тог тасарсан үед “Цус цуглуулах” талаар ЦССҮТөвийн донорын эмч Х.Мядагмаатай хамтран гардан сургалтыг “Цус цуглуулах арга техник, зааварчилгаа, цусны бүлэг тодорхойлох” талаар ажлын байрны дадлагажих сургалтыг хийсэн.











Цусны салбар төв нь 2019 онд хийж бүтээсэн ажлаараа шалгарч  Их эмч Ц.Тунгалаг нь Аймгийн Эрүүл салбарын “шилдэг их эмч”-ээр шалгарсан.







Анхаарал хандуулсанд баярлалаа

